



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/88

Сүхбаатар сум

Газар ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."г", Газрын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.3 2, 44 дүгээр зүйлийн 44.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.3, 28.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны "Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай" 01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тогтсох тухай" А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам /2076675/-д Ган зам 7 дугаар баг Сургуулийн 2 дугаар гудамжны 221 тоотод байрлах 4502 м² газрыг ногоон байгууламжийн зориулалтаар 5 жилийн хугацаагаар ашиглуулсугай.


2. Дээрх газарт кадастрын зураглал хийн, нэгж талбарын хувийн хэрэгт нэмэлт өөрчлөлт оруулж, гэрчилгээ олгон эрхийг нь баталгаажуулж, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэж, холбогдох баримтуудыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд оруулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.

3. Ашиглалтад олгогдсон газраа тохижуулж хамгаалах, газар ашиглах гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэхийг Хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын дарга /Д.Жигжигднямаа/-д үүсэг болгосугай.

4. Ашиглалтад олгогдсон газрын ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801285